МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР
Энхтайван найрамдлын ордон, Энхтайваны өргөн чөлөө,
3 дугаар хороо, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 01 82, Цахим шуудан: info@mmra.gov.mn,
Цахим хуудас: www.mmra.gov.mn

2026.10.22 № 01/1741

танай _____-ны №_____-т

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ХАРЪЯА ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ, БҮСИЙН ОНОШИЛГОО ЭМЧИЛГЭЭНИЙ ТӨВ, АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГА, ЗАХИРАЛ НАРТ

Чиглэл хүргүүлэх тухай

Натрийн бикарбонат 4%-100мл тарилгын шингэн эмийн тасалдалгүй байдлыг хангах хүрээнд зохион байгуулалтыг хийж, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Синофарм группийн харьяа Shijiazhuang No.4 Pharmaceutical Co.Ltd үйлдвэрлэгчээс Натрийн бикарбонат 5%-250мл тарилгын шингэнийг 50,000 ширхэг импортлон, зах зээлийн нөөцийг бүрдүүлсэн.

Иймд Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1.2 дахь заалтын дагуу холбогдох эмийн нөөцийг бүрдүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангаж ажиллана уу.

Натрийн бикарбонат 5%-250мл тарилгын шингэн эмийн аюулгүй байдал, зохистой хэрэглээг хангах, эмийн концентраци, тунгийн тооцоолол, хэрэглэх арга, анхааруулга, болзошгүй эрсдэлийн урьдчилан сэргийлэх зорилгоор хэрэглэх зааврын талаар тус байгууллага эмнэлгийн мэргэжилтэнд зориулсан цахим сургалт зохион байгуулах тул тус сургалтад эмийн эмчилгээний хорооны дарга, чанарын алба, эм зүйн алба, сувилахуйн албаны дарга нар болон холбогдох албан хаагчдыг бүрэн хамруулна уу.

Цахим сургалт 2026 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 12:00 цагт эхэлнэ.

Хавсралтаар: Эмийн зөвлөлийн эм судлалын салбар зөвлөлийн 8 дугаар хурлын шийдвэрийн дагуу баталгаажсан, эрх бүхий байгууллагаар хянагдсан хэрэглэх зааврыг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 6 хуудастай

Эм, эмнэлгийн хэрэгслийн
хяналт, зохицуулалтын газар
Дарга
П.Алтанцэцэг
2026.10.22 17:10

ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР
ЭМИЙН ЗӨВЛӨЛИЙН ЭМ СУДЛАЛЫН САЛБАР
ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНЫ ШИЙДВЭР

2026 оны 10 сарын 21 өдөр Дугаар 08 Улаанбаатар хот

Эм судлалын салбар зөвлөлийн хурал 2026 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 14.00 цагаас 17.00 цагийн хооронд цахимаар хуралдсан. Хуралдаанд Эм судлалын салбар зөвлөлийн дарга Д.Нарантунгалаг, нарийн бичиг Э.Ундармаа, гишүүд М.Эрдэнэтуяа, С.Мөнхбат, Г.Энхмаа, С.Сарнай, Б.Отгонбат, Б.Цэрэнцоо, нар оролцов.

ЗУРГААДУГААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ: ЭЭХХЗГ-аас Натрийн бикарбонат 4%-100 мл тарилгын уусмалын тасалдалгүй хангамжийг хангах зорилгоор БНХАУ-ын Шицзяжуан хотын Эмийн IV үйлдвэрээс импортолж буй Натрийн бикарбонат 5%-250 мл тарилгын уусмалын хэрэглэх заавар, аюулгүй байдал, зохистой хэрэглээтэй холбоотой асуудлыг эмийн сонголтын асуудал хариуцсан мэргэжилтэн Г.Нарангэрэл мэргэжилтэн танилцуулав.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:
Хуралдаанд оролцсон гишүүдийн 77.7% хувийн саналаар дараах шийдвэрийг гаргав.

1. Натрийн бикарбонат 5%-ийн 250 мл тарилгын уусмалын аюулгүй байдал, зохистой хэрэглээг хангах зорилгоор эмийн концентраци, тунгийн тооцоолол, хэрэглэх арга, анхааруулга, болзошгүй эрсдэлийн талаарх мэдээлэл, сургалт, зөвлөмжийг эрүүл мэндийн байгууллагуудад яаралтай зохион байгуулах.
2. Натрийн бикарбонат 5%-ийн 250 мл тарилгын уусмалын үйлдвэрлэгчээс баталгаажуулсан, эрх бүхий байгууллагаар хянагдсан хэрэглэх зааврыг эмийн хамт эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлж, эмнэлгийн тусламж, үйлчилгээнд мөрдүүлэх арга хэмжээ авах.

ЭМ СУДЛАЛЫН САЛБАР
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА Д.НАРАНТУНГАЛАГ

15 20818

Хэрэглэх заавар

Бүтээгдэхүүний нэр

Натрийн Бикарбонат тарилга

Найрлага

Үндсэн нэгдэл ба түүний химийн нэр: Натрийн бикарбонат

Молекул бүтэц: $NaHCO_3$

Молекул жин: 84.01

Бусад: тарилгын ус

Шинж чанар: өнгөгүй, тунгалаг шингэн

Хэрэглэх заалт:

1) Бодисын солилцооны ацидозын эмчилгээ. Бодисын солилцооны хөнгөн, дунд зэргийн ацидозын үед эмийг уулгах нь илүү тохиромжтой. Харин бөөрний хүнд хэлбэрийн өвчин, цусны эргэлтийн дутагдал, зүрх-уушгины сэхээн амьдруулалт, зүрх-уушгины хиймэл эргэлт, сүүн хүчлийн анхдагч хүнд хэлбэрийн ацидоз, чихрийн шижингийн кетоацидоз зэрэг хүнд хэлбэрийн бодисын солилцооны ацидозын үед эмийг судсанд тарьж хэрэглэнэ.
2) Шээс шүлтжих. Шээсний хүчлийн гаралтай бөөрний чулуу үүсэхээс сэргийлэх, сульфаниламидын бүлгийн эмийн бөөрөнд үзүүлэх хортой нөлөөг бууруулах, гемодиализ хийх үед, мөн бөөрний сувганцарт гемоглобин хуримтлагдахаас сэргийлэх зорилгоор хэрэглэнэ.
3) Хэт хүчилшилтээс үүдэлтэй шинж тэмдгүүдийг эмчлэхэд зориулсан хүчил саармагжуулах (антацид) зорилгоор
4) Судсанд дуслаар тарих эмчилгээ нь барбитурат, салицилийн хүчлийн бүлгийн эмүүд, метанол зэрэг тодорхой төрлийн хордлогын үед эмчилгээний ерөнхий нөлөө үзүүлдэг. Гэхдээ хүчтэй хүчил залгисан тохиолдолд ходоод угаахад энэ бодисыг хэрэглэхийг хориглоно. Учир нь хүчтэй хүчилтэй урвалд орж их хэмжээний нүүрстөрөгчийн давхар исэл ялгаруулснаар ходоод огцом тэлэгдэх, цаашлаад ходоод цоорох эрсдэлтэй.

Хэмжээ:

250мл: 12.5г

Тун, хэрэглэх арга

Бодисын солилцооны хүчилшилийн үед судсанд дуслаар хийх шаардлагатай тунг дараах томьёогоор тооцоолно:

ТТМ2645 6654894

2026. 10. 21, №8.

Шүлт нөхөх хэмжээ (ммоль) = (-2.3 - бодит хэмжээт BE утга) × 0.25 × биеийн жин (кг), эсвэл шүлт нөхөх хэмжээ (ммоль) = (хэвийн CO2CP - бодит хэмжсэн CO2CP (ммоль)) × 0.25 × биеийн жин (кг).

Бие махбодоос бикарбонат алдагдсан тохиолдол байхгүй бол эхлээд тооцоолсон тунгийн 1/3~1/2 хийх бөгөөд дуслыг 4~8 цагийн дотор хийж дуусгана.

Зүрх-уушгины сэхээн амьдруулах (ЗУСА) арга хэмжээний үед эхний удаад 1 ммоль/кг тунгаар хэрэглэх ба цаашдын тунг цусны хийн шинжилгээний үр дүнд үндэслэн тохируулна (1 г натрийн бикарбонат нь 12 ммоль бикарбонаттай тэнцэнэ).

Судсанд эм тариа хийхдээ дараах зүйлсийг анхаарна:

1) Судсанд хийх үеийн концентрацын хязгаар нь 1.5% (изотоник)-8.4% хүртэл байна; (2)
2) Бага тунгаар эхэлж, улмаар цусны pH утга болон бикарбонатын концентрацын өөрчлөлтөд үндэслэн нэмэлт тунг тогтооно. Богино хугацаанд их хэмжээний уусмал судсанд дусаах нь хүнд хэлбэрийн шүлтшил, цусан дахь кали болон кальцийн түвшин буурах (гипокалиеми, гипокальциеми) шалтгаан болж болзошгүй. Гипертоник уусмалыг минутад 10 мл-ээс дээш хурдаар хийх нь цусан дахь натрийн хэмжээ хэт ихсэх (гипернатриеми), нугас-тархины шингэний даралт буурах, цаашлаад гавлын дотоод цус алдалт үүсгэх эрсдэлтэй бөгөөд энэ нь нярай болон 2-оос доош насны хүүхдүүдэд илүү тохиолдох магадлалтай. Иймд 5%-ийн уусмал дусаах үед натрийн хэмжээг минутад 8 ммоль-оос хэтрүүлж болохгүй. Гэхдээ ЗУСА-ийн үед үхэлд хүргэж болзошгүй хүчилшил үүсдэг тул судсанд хурдан дусаах шаардлагатай болдог.

Шээсийг шүлтжүүлэх зорилгоор: Насанд хүрэгчдэд эхний удаад 4 г уулгаж, цаашид 4 цаг тутамд 1~2 г өгнө.

Судсанд дуслаар 2~5 ммоль/кг тунгаар, 4~8 цагийн дотор дусаана.

Нярай, бага насны хүүхдэд: Биеийн жинд нь тохируулан хоногт 1~10 ммоль/кг тунгаар уулгана.

Сөрөг нөлөө

1. Их хэмжээний тарилгын үед голдуу бодисын солилцооны хүчилшилийн шалтгаант гипокалиемиас үүдэлтэй хэм алдагдал, булчингийн агшилт, өвдөлт, хэвийн бус ядрал, бие сулрал гэх мэт шинж тэмдэг илэрч болно.
2. Тун хэт их байх эсвэл бөөрний дутагдал, хаван, сэтгэцийн шинж тэмдэг, булчингийн өвдөлт эсвэл таталт, амьсгал удаашрах, амнаас өвөрмөц үнэр гарах, хэвийн бус ядрал, бие сулрах байдал үүсч болно. Энэ нь голдуу бодисын солилцооны хүчилшилээс үүсдэг.
3. Удаан хугацаагаар хэрэглэх нь ойр ойрхон шээх, шээс задгайрах, толгой өвдөх, хоолны дуршил буурах, дотор муухайрах, бөөлжих, хэвийн бус ядрал, бие сулрах шинж тэмдгүүдийг үүсгэдэг.

ТТМ2645 6654894

Хориглох заалт

Тодорхойгүй.

Онцгой анхааруулга, хэрэглээнд тавигдах урьдчилан сэргийлэлт

1) Оношилгоонд саад учруулах: Энэ нь ходоодны хүчил ялгаруулалтын шинжилгээ, эсвэл цус, шээсний pH-ийн шинжилгээний үр дүнд илэрхий нөлөө үзүүлдэг.
2) Дараах тохиолдлуудад болгоомжтой хэрэглэнэ:
    a) Шээс багасах (олигури) эсвэл шээс гарахгүй болох (анури) үед (натрийн ачааллыг нэмэгдүүлж болзошгүй);
    b) Элэгний хатуурал, зүрхний дутагдал, бөөрний дутагдал, жирэмслэлтийн улмаас үүссэн даралт ихсэх хам шинж зэрэг натри хуримтлагдах болон хаван үүсэх нөхцөлүүдийн үед;
    c) Үндсэн шалтгаант даралт ихсэх өвчин (натрийн ачаалал нэмэгдсэнээр өвчний явцыг хүндрүүлж болзошгүй).
3) Дараах нөхцөлүүдэд судсанд тарилга хэлбэрээр хэрэглэж болохгүй:
    a) Бодисын солилцооны эсвэл амьсгалын гаралтай шүлтлэгжил (алкалоз);
    b) Бөөлжих эсвэл ходоод гэдэсний замыг тасралтгүй соруулж цэвэрлэх (сөрөг даралтаар соруулах) үед хлорид их хэмжээгээр алдагдсанаас бодисын солилцооны шүлтлэгжил үүсэх өндөр эрсдэлтэй үед;
    c) Цусан дахь кальцийн хэмжээ багасах (гипокальциеми) үед — энэ бэлдмэлээс үүдэлтэй шүлтлэгжил нь гипокальциемийн шинж тэмдгүүдийг улам хүндрүүлж болзошгүй.
4) Энэхүү бэлдмэлийн осмосын даралтын моляр концентрацын харьцаа 3.0–3.6 байх ёстой.

Жирэмсэн, хөхүүл үе

1) Удаан хугацаагаар эсвэл их тунгаар хэрэглэх нь бодисын солилцооны алкалоз (цусны шүлтлэг чанар хэт нэмэгдэх) үүсгэж болзошгүй бөгөөд натрийн хэт их ачаалал нь хаван үүсгэх сөрөг нөлөөтэй. Жирэмсэн эмэгтэйчүүдэд болгоомжтой хэрэглэх шаардлагатай.
2) Энэхүү бэлдмэл нь хөхний сүүгээр ялгарч болзошгүй боловч хөхүүл хүүхдэд үзүүлэх нөлөөний талаар хангалттай мэдээлэл, судалгаа байхгүй.

Бага насны хүүхдэд

Ацидозыг эмчлэхдээ насанд хүрэгчдэд зориулсан тунг баримтална. Зүрх-уушгины сэхээн амьдруулах арга хэмжээний үед эхний удаад судсанд тарих тун нь биеийн жинд харьцуулахад 1 ммоль/кг байна. Үүний дараа цусан дахь үзүүлэлтүүдийн шинжилгээний хариунд үндэслэн тунг тохируулна.

ТТМ2645.a 6654894

Өндөр настанд

Тодорхойгүй.

Харилцан нөлөө

1) Бөөрний дээд булчирхайн холтослог давхаргын даавруудтай (ялангуяа эрдэс зохицуулах хүчтэй үйлчилгээтэй даавруудтай) хамт хэрэглэхэд цусан дахь натрийн хэмжээ хэт ихсэх (гипернатриеми) болон хаван үүсэх эрсдэлтэй.
2) Амфетамин, хинидин зэрэг эмүүдтэй хамт хэрэглэхэд эдгээр эмийн бөөрөөр ялгаралт буурч, улмаар хордлогын шинж тэмдэг илрэх магадлалтай.
3) Варфарин зэрэг цусны бүлэгнэлтийн эсрэг эмүүд болон М-холиномиметик (холинэстераза дарангуйлагч) бүлгийн эмүүдтэй хамт хэрэглэхэд эмийн шимэгдэлт буурдаг.
4) Кальци агуулсан эмүүд, сүү, сүүн бүтээгдэхүүнүүдтэй хамт хэрэглэх нь "сүү-шүлтийн хам шинж"-ийг үүсгэж болзошгүй.
5) Циметидин, ранитидин болон бусад Н2-рецептор хориглогч эмүүдтэй хамт хэрэглэхэд эдгээр эмийн шимэгдэлт буурдаг.
6) Кали ялгаруулалтыг нэмэгдүүлдэг шээс хөөх эмүүдтэй хамт хэрэглэх нь гипохлоремийн алкалоз (цусны хүчил-шүлтийн тэнцвэр шүлтлэг тал руу хэлбийх) үүсэх эрсдэлийг нэмэгдүүлнэ.
7) Энэхүү бэлдмэл нь шээсийг шүлтлэг болгодог тул бөөрөөр ялгарах эфедриний хэмжээнд нөлөөлдөг. Иймд эфедринтэй хамт хэрэглэх тохиолдолд эфедриний тунг бууруулах шаардлагатай.
8) Натрийн хэмжээ ихсэх нь бөөрөөр ялгарах литийн хэмжээг нэмэгдүүлдэг тул лити агуулсан бэлдмэлүүдтэй хамт хэрэглэх үед литийн тунг тохируулах хэрэгтэй.
9) Шээс шүлтлэг болох нь уротропиныг формальдегид болгон хувиргахыг саатуулж, улмаар түүний эмчилгээний үр нөлөөг бууруулдаг тул эдгээр хоёр эмийг хамт хэрэглэхийг зөвлөдөггүй.
10) Энэхүү бэлдмэл нь шээсийг шүлтлэг болгосноор салицилийн хүчлийн төрлийн эмүүдийн бөөрөөр ялгарах хэмжээг нэмэгдүүлж болзошгүй.

Тун хэтрүүлэлт

Тодорхойгүй.

Эм судлал, тун

1) Бодисын солилцооны ацидозыг (хүчил-суурийн тэнцвэрийн алдагдал) эмчлэхэд энэхүү бэлдмэл нь плазм дахь бикарбонатын агууламжийг нэмэгдүүлж, устөрөгчийн ионуудыг саармагжуулах замаар ацидозыг засдаг;
2) Шээсний орчныг шүлтлэгжүүлэх: Шээсэнд бикарбонатын агууламж нэмэгдэхэд pH-ийн үтга өсөж, улмаар шээсний хүчил, сульфаниламидын бүлгийн эмүүд болон гемоглобин нь шээсэнд талст эсвэл бөөгнөрөл үүсэлтийг хязгаарладаг;
3) Хүчил саармагжуулах үйлдэл: уух үед ходоодны хүчлийн ялгаралтад шууд нөлөөлөхгүйгээр, ходоодны хүчлийг хурдан саармагжуулдаг буюу буферлэдэг.

ТТМ2645 6654894

Үүний дүнд ходоодны орчны pH хурдан өсөж, ходоодны хүчлээс үүдэлтэй шинж тэмдгүүдийг намдаадаг.

Фармакокинетик

Энэ бүтээгдэхүүнийг судсанд тарихад шууд цусны эргэлтэд ордог. Цусан дахь бикарбонатыг бөөрний түүдгэнцрүүд шүүж, шээсээр дамжуулан гадагшлуулдаг. Шээсэн дэх зарим бикарбонат ионууд устөрөгчийн ионуудтай нэгдэж нүүрсхүчлийн хүчил үүсгэн цааш задарч нүүрстөрөгчийн давхар исэл болон ус болдог. Нүүрстөрөгчийн давхар исэл нь бөөрний сувганцрын эсүүд рүү нэвтрэн бөөрд устай нэгдэн нүүрсхүчлийн хүчил үүсгэн улмаар задарч, бикарбонат ионууд нь цусны эргэлт рүү эргэн шимэгддэг. Мөн цусан дахь бикарбонат ионууд устөрөгчийн ионуудтай нэгдэж нүүрсхүчлийн хүчил үүсгэх ба энэ нь нүүрстөрөгчийн давхар исэл, ус болон задардаг; үүссэн нүүрстөрөгчийн давхар исэл нь уушгиар дамжин амьсгалаар гадагшилдаг.

Хадгалах нөхцөл

Битүүмжлэлтэй саванд хадгална.

Савлалт

Зөөлөн уутанд 250мл савлагдсан.

Маркетингийн зөвшөөрөл эзэмшигч

Нэр: Шицзяжуан хотын 4-р эмийн үйлдвэр ХХК

Хаяг: БНХАУ, Хэбэй муж, Шицзяжуан хот, Өндөр технологийн аж үйлдвэрийн хөгжлийн бүс, Хуайань зам (зүүн), 518 тоот

ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН НЭР, ХАЯГ

Нэр: Шицзяжуан хотын 4-р эмийн үйлдвэр ХХК

Хаяг: БНХАУ, Шицзяжуан хот, Эдийн засаг, технологийн хөгжлийн бүс, Янзи зам

